



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Т.Одсүрэн

Утас: 70362442 Цахим хаяг: odsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Аудитын гол асуудал	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Акт	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БҮХТ	Боловсролын үнэлгээний хөгжлийн төв



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II бар
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2023.02.16 № СЭА-2023/226-НА СТАТУС
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ч.АЛТАНТУЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.4 хувьтай тайлагнагдсан бөгөөд НДШ-ийн зардлыг 11.6 хувиар, тогтмол зардлыг 2.1 хувиар, хангамж, бараа материалын зардлыг 1.6 хувиар, эд хогшил, урсгал засварын зардлыг 5.6 хувиар, дотоод албан томилолтын зардлыг 6.1 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 3.1 хувиар тус тус хэмнэснээс голлон шалтгаалж нийт төсөв 0.6 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 88.4 хувийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн

зардал эзэлж байгаа бөгөөд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 314,246.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 39,475.1 хангамж, бараа материалын зардалд 12,627.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 17,123.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 31,818.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.


ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан



Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	10,236,739.00	11,490,379.00
33	АВЛАГА	-	1,050,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	1,050,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,236,739.00	10,440,379.00
35400	Хангамжийн материал	10,236,739.00	10,440,379.00
35420	Аж ахуйн материал	10,236,739.00	9,456,379.00
35440	Түлш, шатах тослох материал	-	500,000.00
35450	Барилгын засварын материал	-	484,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	242,756,929.80	172,155,558.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	242,756,929.80	172,155,558.06
39200	Биет хөрөнгө	242,756,929.80	172,155,558.06
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,821,075.00	69,821,075.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,866,666.73)	(32,577,204.29)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	231,971,099.78	250,722,796.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(66,582,871.78)	(124,760,923.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,406,220.49	26,406,220.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,761,926.96)	(18,276,406.27)
39217	Ном	770,000.00	820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	252,993,668.80	183,645,937.06
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	50,000.00	1,050,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,000.00	1,050,000.00
41300	Өглөг	50,000.00	1,050,000.00
41360	Бусад өглөг	-	1,050,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,050,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	252,943,668.80	182,595,937.06
51	Засгийн газрын хувь оролцоо	252,943,668.80	182,595,937.06
51100	Засгийн газрын оруулсан капитал	211,787,128.44	211,787,128.44
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	211,787,128.44	211,787,128.44
51200	Хуримтлагдсан үр дүн	41,156,540.36	(29,191,191.38)
51210	Өмнөх үеийн үр дүн	(24,228,471.11)	41,156,540.36
51220	Тайлант үеийн үр дүн	65,385,011.47	(70,347,731.74)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	252,993,668.80	183,645,937.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,678,059,716.45	4,501,635,610.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	182,991,201.45	214,192,966.40
120	Нийтлэг татварын бус орлого	182,991,201.45	214,192,966.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	167,642,901.45	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	167,642,901.45	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,861,300.00	9,195,706.47

120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,487,000.00	204,997,259.93
121	Хөрөнгийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,495,068,515.00	4,287,442,644.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,227,153,400.00	4,144,796,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,153,400.00	4,144,796,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	267,915,115.00	142,646,044.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,921,350.00	13,321,275.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	257,760,215.00	129,324,769.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,233,550.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,612,383,552.68	4,571,983,342.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,612,383,552.68	4,571,983,342.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,615,589.39	842,827,819.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,812,878.88	314,196,108.57
210101	Үндсэн цалин	188,615,123.30	205,047,922.99
210102	Нэмэгдэл	48,668,809.51	56,494,865.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,337,500.00	31,807,800.00
210104	Урамшуулал	13,191,446.07	20,845,520.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,094,530.92	39,475,154.65
210201	Тэтгэврийн даатгал	24,503,414.27	27,183,128.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,719,389.01	3,183,448.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,099,743.42	2,529,298.82
210204	Ажилгүйдлийн даатгал	524,725.76	598,116.31
210205	Эрүүл мэндийн даатгал	5,247,258.46	5,981,163.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,911,540.91	31,817,994.51
210301	Гэрэл, цахилгаан	3,711,454.91	3,072,810.51
210302	Түлш, халаалт	18,470,356.00	27,859,574.00
210303	Цэвэр, бохир ус	729,730.00	885,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	132,007,081.68	230,633,418.93
210401	Бичиг хэрэг	12,703,795.00	2,798,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,196,350.00	11,478,569.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,527,390.00	908,090.00
210404	Ном, хэвлэл	240,000.00	24,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,191,200.00	217,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	691,750.00	3,611,050.00
210408	Бараа материал акталсны зардал	341,260.00	2,665,450.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	92,115,336.68	208,930,259.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,693,500.00	5,159,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	500,000.00
210604	Урсгал засвар	4,693,500.00	4,659,800.00
2107	Томилот, зочны зардал	1,400,500.00	17,232,150.00
210702	Дотоод албан томилот	1,400,500.00	17,232,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	209,731,115.00	46,819,674.37

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,361,070.00	46,476,929.37
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,120.00	88,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,000.00	53,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63,964,442.00	157,493,518.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	328,000.00	18,666,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,021,851.00	49,424,250.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,614,591.00	89,403,068.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,880,767,963.29	3,729,155,522.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,678,799,147.00	3,705,335,772.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	744,422,153.00	1,049,669,750.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	934,049,394.00	2,593,841,022.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	327,600.00	61,825,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,968,816.29	23,819,750.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,932,816.29	23,817,359.20
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	36,000.00	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,391.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	65,676,163.77	(70,347,731.74)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	291,152.30	-
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	291,152.30	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	65,385,011.47	(70,347,731.74)
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	-	-
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,495,068,515.00	4,287,442,644.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,495,068,515.00	4,287,442,644.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,227,153,400.00	4,144,796,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,227,153,400.00	4,144,796,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	267,915,115.00	142,646,044.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,921,350.00	13,321,275.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	257,760,215.00	129,324,769.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,233,550.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,471,213,015.00	4,277,836,654.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,471,213,015.00	4,277,836,654.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	590,445,051.71	547,631,131.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	261,764,878.88	314,246,108.57
210101	Үндсэн цалин	188,567,123.30	207,685,265.53
210102	Нэмэгдэл	48,668,809.51	55,304,274.07
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,337,500.00	30,804,700.00
210104	Урамшуулал	13,191,446.07	20,451,868.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,002,130.92	39,475,154.65
210201	Тэтгэврийн даатгал	24,432,854.27	27,183,128.24
210202	Тэтгэмжийн даатгал	2,715,189.01	3,183,448.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,091,343.42	2,529,298.82
210204	Ажилгүйдлийн даатгал	523,885.76	598,116.31
210205	Эрүүл мэндийн даатгал	5,238,858.46	5,981,163.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,911,540.91	31,817,994.51
210301	Гэрэл, цахилгаан	3,711,454.91	3,072,810.51
210302	Түлш, халаалт	18,470,356.00	27,859,574.00
210303	Цэвэр, бохир ус	729,730.00	885,610.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,985,285.00	23,431,699.00
210401	Бичиг хэрэг	12,790,195.00	6,731,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,621,350.00	11,978,569.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,527,390.00	908,090.00
210404	Ном, хэвлэл	240,000.00	24,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,117,600.00	217,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	688,750.00	3,572,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,161,000.00	7,567,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	467,500.00	2,424,100.00
210604	Урсгал засвар	4,693,500.00	5,143,800.00
2107	Томилолт, зочны зардал	658,500.00	17,232,150.00
210702	Дотоод албан томилолт	658,500.00	17,232,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	211,611,865.00	46,819,674.37
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,241,820.00	46,476,929.37
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	200,925.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	98,120.00	88,120.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	63,000.00	53,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,349,851.00	67,040,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	328,000.00	18,666,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,021,851.00	48,374,250.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,880,767,963.29	3,730,205,522.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,678,799,147.00	3,705,335,772.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	744,422,153.00	1,049,669,750.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	934,049,394.00	2,593,841,022.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	327,600.00	61,825,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,968,816.29	24,869,750.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	201,932,816.29	23,817,359.20

213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	36,000.00	1,052,391.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	23,855,500.00	9,605,990.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	23,855,500.00	9,605,990.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,855,500.00	9,605,990.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,855,500.00	9,605,990.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,855,500.00	9,605,990.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(23,855,500.00)	(9,605,990.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	(25,628,575.56)	187,558,657.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,400,104.45	1,400,104.45
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	1,400,104.45	(24,228,471.11)	188,958,761.78
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,400,104.45)	-	(1,400,104.45)
9	Тайлант үеийн үр дүн	-	-	65,385,011.47	65,385,011.47
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	41,156,540.36	252,943,668.80
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	41,156,540.36	252,943,668.80
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,787,128.44	-	41,156,540.36	252,943,668.80
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(70,347,731.74)	(70,347,731.74)
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,787,128.44	-	(29,191,191.38)	182,595,937.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,144,796,600.00	4,120,979,240.80	(9,605,990.00)	99.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,144,796,600.00	4,120,979,240.80	(9,605,990.00)	99.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	486,329,600.00	475,643,468.80	(9,605,990.00)	97.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,113,300.00	314,246,108.57	-	99.41
210101	Үндсэн цалин	190,035,300.00	207,685,265.53	-	109.29
210102	Нэмэгдэл	71,422,700.00	55,304,274.07	-	77.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,944,000.00	30,804,700.00	-	96.43
210104	Урамшуулал	22,711,300.00	20,451,868.97	-	90.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,639,100.00	39,475,154.65	-	88.43
210201	Тэтгэврийн даатгал	30,354,600.00	27,183,128.24	-	89.55
210202	Тэтгэмжийн даатгал	3,571,100.00	3,183,448.25	-	89.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,856,900.00	2,529,298.82	-	88.53
210204	Ажилгүйдлийн даатгал	714,200.00	598,116.31	-	83.75
210205	Эрүүл мэндийн даатгал	7,142,300.00	5,981,163.03	-	83.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,512,400.00	31,817,994.51	-	97.86
210301	Гэрэл, цахилгаан	3,500,100.00	3,072,810.51	-	87.79
210302	Түлш, халаалт	27,877,000.00	27,859,574.00	-	99.94
210303	Цэвэр, бохир ус	1,135,300.00	885,610.00	-	78.01
2104	Хангамж, бараа материалын зардал	12,829,100.00	12,627,130.00	(50,000.00)	98.43
210401	Бичиг хэрэг	2,296,800.00	2,064,800.00	-	89.90
210402	Тээвэр, шатахуун	5,998,000.00	5,995,000.00	-	99.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,218,200.00	704,090.00	-	57.80
210404	Ном, хэвлэл	189,800.00	74,000.00	(50,000.00)	38.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,388,000.00	217,200.00	-	15.65
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,738,300.00	3,572,040.00	-	205.49
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,146,400.00	17,123,890.00	(9,555,990.00)	94.37
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	11,980,090.00	(9,555,990.00)	99.83
210604	Урсгал засвар	6,146,400.00	5,143,800.00	-	83.69
2107	Томилолт, зочны зардал	2,269,700.00	2,130,200.00	-	93.85
210702	Дотоод албан томилолт	2,269,700.00	2,130,200.00	-	93.85
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,515,300.00	43,153,541.07	-	96.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	44,146,500.00	42,810,796.07	-	96.97

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан



Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	142,646,044.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	142,646,044.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,593,652.30
2104	Хангамж, бараа материалын зардал	10,854,569.00
210401	Бичиг хэрэг	4,667,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,983,569.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	204,000.00
2107	Томилолт, зочны зардал	15,101,950.00
210702	Дотоод албан томилолт	15,101,950.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,971,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,626,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	34,344,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,052,391.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	60,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,052,391.70
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,052,391.70
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	142,646,044.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	142,646,044.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,321,275.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	117,733,270.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	11,591,499.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь цаашид (БШУГ) “Боловсролын байгууллагын ажилтан, албан хаагч, багш нарын мэргэжлийн ур чадварыг ямагт хөгжүүлэн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд залуучуудад чанартай боловсрол олгож, бие даан суралцах, амьдрах чадвартай, ёс заншил уламжлалаа дээдэлсэн хүмүүнлэг иргэн болгон төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах.
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг үүсгэн байгуулах, өөрчлөх, тусгай зөвшөөрөл олгох эсэх талаар дүгнэлт гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад санал болгох.
- Багш, ажилтны хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, нийгмийн баталгааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх.
- Боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох эрх зүйн баримт бичигт заасны дагуу эрх бүхий байгууллагад гаргаж өгөх.
- Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох.
- Орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах.
- Орон нутгийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дүрэмт хувцасны нэгдсэн загвар батлах.
- Шинжлэх ухаан, технологи, инновацын хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах, удирдлага, зохицуулалтаар хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.

- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн БШУГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.



3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн БШУГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 69,347.8 мянган төгрөгөөр буюу 27.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага		1,050.0	(1,050.0)
Бараа материал	10,236.8	10,440.4	203.6
Үндсэн хөрөнгө	242,756.9	172,155.5	(70,601.4)
Нийт хөрөнгө	252,993.7	183,645.9	(69,347.8)
Өр төлбөр	50.0	1,050.0	1,000.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	252,943.7	182,595.9	(70,347.8)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	252,993.7	183,645.9	(69,347.8)

Дотуур байран дахь суралцагчийн эрх хамгааллын аюулгүй байдлын зардлын санхүүжилтийг 12 дугаар сарын 30-ны өдөр нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэнтэй холбоотойгоор тайлант онд зарцуулах боломжгүй байдалд хүрч төсөвт татан төвлөрүүлснээр 1,050.0 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 347,770.1 мянган төгрөг болж 18,801.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 9,606.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ном худалдан авсан, БШУЯ-наас үнэ төлбөргүйгээр 6,055.5 мянган төгрөгийн зөөврийн компьютер шилжүүлэн өгсөн, БНСУ-ын Жэжү тусгай мужийн Боловсролын газраас буцалтгүй тусламжийн хандиваар 3,140.2 мянган төгрөгийн суурин компьютерыг хүлээн авсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 182,595.9 мянган төгрөг болж 70,347.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 501,937.2 мянган төгрөг, нийт зарлагыг 501,937.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас бараа ажил үйлчилгээний зардлыг 13,336.4 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 488,600.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, нормативт зардал, томилолтын зардал, бараа үйлчилгээний зардлуудыг бууруулснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 3,656,195.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна. Энэ нь сургууль, цэцэрлэгийн багш нарын тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад 5 жил тутамд нэг удаа олгох мөнгөн урамшууллын санхүүжилтийг нэмэгдүүлснээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,144,796.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,144,796.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,120,979.2 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 1,867.2 мянган төгрөг, НДШ-ийн зардлаас 5,163.9 мянган төгрөг, тогтмол зардлаас 694.4 мянган төгрөг, хангамжийн материалын зардлаас 202.0 мянган төгрөг, урсгал зардлаас 1,022.5 мянган төгрөг, томилолтын зардлаас 139.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжаас 1,361.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 234.8 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлаас 7,858.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох дэмжлэгийн зардлаас 5,269.7 мянган төгрөгийг тус тус хэмнэж, улсын төсөвт нийт 23,817.4 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71801 - Сургуулийн өмнөх боловсрол	80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж,	1,042,574.0	1,041,370.6	1,203.4	99.9
2	71802- Ерөнхий боловсрол	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	2,574,873.3	2,562,948.5	11,924.8	99.5

3	71808- Боловсрол, ШУ-ны бодлого, удирдлага	80801-Үндсэн үйл ажиллагааны зардал	486,329.6	475,643.5	10,686.1	97.8
		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	41,019.7	41,016.6	3.1	100.0
Бүгд дүн			4,144,796.6	4,120,979.2	23,817.4	99.4



Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дараах 142,646.0 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

- БШУЯ-аас сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зөвлөн туслах, хяналт-шинжилгээ хийх, сургалтын зардал 3,793.5 мянган төгрөг,
- БЕГ-аас тоглонгоо суралцъя, унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүйг хэрэгжүүлэх, боловсролын чанарын шинэчлэлт, бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга зүй, бидний хөтөч, математикийн багш нарт хийх цахим сургалтын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд 113,000.3 мянган төгрөг,
- БҮХТ-өөс боловсролын үнэлгээний шалгалтын бичиг хэргийн зардалд 3,933.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон мөрийн хөтөлбөрийн батлагдсан төсвөөс хөдөөгийн багш нарын спортын XIX их наадамд оролцох багш нарын тэмцээний хураамж, замын зардал, боловсрол, сургалтын байгууллагад хэрэглэгдэж байгаа химийн бодисыг зайлуулах, тээвэрлэх, устгах, СӨБ-ын тогооч нарын сургалт, улсын төрөлжсөн олимпиадад оролцох багш нарын хоол байр, замын зардал, 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлын хүрээнд зөвлөх багш нараас багш нарт зохион байгуулах сургалтын зардал зэрэгт нийт 21,919.2 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу БШУГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр, ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

БШУГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 28 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,678,059.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 25,951.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **18,286.7** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор БЕГ-аас 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахмжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Аймгийн БШУГ-ын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, хангамжийн материал, урсгал зардал, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох дэмжлэгийн зардлуудаас нийт 23,817.4 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Боловсролын газрын мэдээлбэл зохих 22 төрлийн 175 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас шалтгаалан нэр бүхий 2 албан хаагчид 145.4 мянган төгрөгийн хавсран ажилласны нэмэгдэл илүү олгосон зөрчлийг 2022 оны цалингаас нөхөн суутгах албан

шаардлага болон бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 4,317.7 мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж тайлант онд давтан гаргаагүй байна.



Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	145.4	1	145.4	100
Зөвлөмж	1	4,317.7	1	4,317.7	100
Нийт дүн	2	4,463.1	2	4,463.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Сэлэнгэ аймгийн БШУГ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:


1. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн төрийн захиргааны байгууллага / аймгийн БШУГ /-ын үйл ажиллагааны үр дүнг гүйцэтгэлээр санхүүжүүлэх, үнэлж, дүгнэх, урамшуулах эрх зүйн орчин бүрдээгүй байхад БШУ-ны сайдын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А/552 дугаар тушаалаар боловсролын салбарт үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлэхэд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр 3 дугаар байранд шалгарсан үндэслэлээр аймгийн БШУГ-ын албан хаагчдын үр дүнгийн урамшуулал гэж нийт 60,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Тус газрын албан хаагчдад улирал бүр ажлын үр дүнгээр олгож буй 40.0 хүртэл хувийн мөнгөн урамшуулалтай давхардуулан дээрх 60,000.0 мянган төгрөгийг эрх зүйн үндэслэлгүйгээр хүн тус бүрт 1,230.0-6,000.0 мянган төгрөг байхаар / ямар үр дүнг харгалзуулан хуваарилсан нь тодорхой бус / хуваарилж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх” Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 : ” Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох “ гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд зохион байгуулсан “Тоглонгоо суралцъя”, “Унших ба бодох чадварын хөгжүүлэх арга зүй” арга хэмжээнүүдэд зарцуулсан 327.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын жолооны тооцооны хуудсанд автомашины спидометрийн заалт, шатахууны норм, зарцуулалтыг тайлагнаагүй, зөвхөн явах маршрутаар тооцож олгосон байна. Ингэснээр зарцуулсан шатахуун нь 100км/т зарцуулах нормтойгоо уялдаагүй бөгөөд өөрийн амьдран суудаг суманд зөвлөн

туслах сургалтыг зохион байгуулсан албан хаагчдад 3,180.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардал тус тус олгож, бүртгэл тайланд тусгасан байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”. 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтууд болон Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журмын 2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 17,689.8 мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 1,350.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 16,339,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.1 Акт

1. Нягтлан бодогч Ц.Цэцэгмаа, төсвийн мэргэжилтэн П.Золжаргал нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны А/57 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно*”, 15.1.3 : “*Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах зарчмыг алдагдуулж төрийн албан хаагчдад дараах нөхөн олговрыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, ЗГ-ын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “*Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам*”-ын 8.2 дахь “*Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын*

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно”, 8.4 дэх “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Жилийн эцэс буюу тайлант оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа, хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 4.5 мянган төгрөг байсан / 2022 оны 4 дүгээр сард шинэчлэн тогтоосон / хоолны хөнгөлөлтийг аймгийн БШУ-ны газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяагийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалаар 13.5 мянган төгрөг болгон 3.0 дахин нэмэгдүүлж, нийт **6,471.0 мянган** төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна.

2. Аймгийн төв болох Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээгүй байхад газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалаар хүн тус бүрт өдөрт 2.5-3.0 мянган төгрөгийн, нийт **9,868.8** мянган төгрөгийн нийтийн тээврийн унааны зардлын нөхөх төлбөр олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
Дүн							Тоо	Дүн	Тоо	Дүн



Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Үүнээс											
Мөнгөн урамшуулал давхар-дуулан олгосон	1	1,350.0	1	1,350.0								
Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	16,339.8			1	16,339.8						
Дүн	2	17,689.8	1	1,350.0	1	16,339.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

БАТЛАВ.
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.ЭНХТУЯА



2023 оны 02 дугаар сарын 13

Сүхбаатар сум

МЭДЭГДЭЛ

Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт

Сонсох ажиллагаа явуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх "Төрийн аудитын байгууллага аудитын тайлангийн дүнгийн улмаас аудитад хамрагдагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж болзошгүй тохиолдолд энэ талаар санал, хүсэлт, тайлбар, гомдол гаргах боломжийг олгоно." гэж заасны дагуу "Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн хавсралтад дурдсан алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоох болсон тул Захиргааны Ерөнхий хуульд заасны дагуу 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 15 цагт сонсох ажиллагааг биечлэн уулзах хэлбэрээр явуулах болсныг үүгээр мэдэгдэж байна.

Сонсох ажиллагаа нь дараах дарааллаар явагдана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэлийг танилцуулах;
2. Захиргааны шийдвэр гаргах асуудлын талаарх үндэслэл, шалтгаан нөхцөлийг танилцуулах;
3. Санал сонсох.

Мэдэгдлийг гардуулж өгсөн:

Аудитор _____ /Г.Одсүрэн/
албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг хүлээн авсан:

Нягтлан бодогч _____ /Ц.Цэцэгмаа/
албан тушаал гарын үсэг

Мэдэгдлийг гардуулж өгсөн огноо: 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

**СОНСОХ АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ТУХАЙ
ТЭМДЭГЛЭЛ**

№_01_

2023 оны 02-р сарын 14-ний өдөр

Сүхбаатар сум

Захиргааны ерөнхий хуулийн дагуу Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга, нягтлан бодогч, төсвийн мэргэжилтэн нартай 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 14 цаг 36 минутад биечлэн уулзах хэлбэрээр сонсох ажиллагааг явууллаа.

Сонсох ажиллагаанд байгууллагыг төлөөлж:

Албан тушаал, нэр: Сэлэнгэ аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяа

Албан тушаал, нэр; Нягтлан бодогч Ц.Цэцэгмаа

Албан тушаал, нэр; Төсвийн мэргэжилтэн П.Золжаргал

Сонсох ажиллагааны бүрэлдэхүүнээс татгалзал бий эсэх:

Татгалзаж байгаа шалтгаан:
.....*Байхгүй*.....

Гарын үсэг: Дарга

/Ч.Алтантуяа/

Бүрэлдэхүүнийг зөвшөөрч байна.

Гарын үсэг: Нягтлан бодогч

/Ц.Цэцэгмаа/

Гарын үсэг: Төсвийн мэргэжилтэн

/П.Золжаргал /

Сонсох ажиллагаа явуулах болсон шалтгаан: Мэдэгдэлд дурдагдсан захиргааны шийдвэрийн хууль, эрх зүйн үндэслэл, Захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх шалтгаан нөхцөл, үндэслэлтэй холбоотойгоор аудитаар нийт **17,689.8** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, 1,350.0 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт, 16,339,8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн Үүнд:

1. Нягтлан бодогч Ц.Цэцэгмаа, төсвийн мэргэжилтэн П.Золжаргал нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны А/57 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3: "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах зарчмыг алдагдуулж төрийн албан хаагчдад дараах нөхөн олговрыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, ЗГ-ын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 8.2 дахь “Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно”, 8.4 дэх “Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Жилийн эцэс буюу тайлант оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа, хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 4.5 мянган төгрөг байсан /2022 оны 4 дүгээр сард шинэчлэн тогтоосон/ хоолны хөнгөлөлтийг аймгийн БШУ-ны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяагийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалаар 13.5 мянган төгрөг болгон 3.0 дахин нэмэгдүүлж, нийт **6,471.0 мянган** төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна.

2. Аймгийн төв болох Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээгүй байхад газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалаар хүн тус бүрт өдөрт 2.5-3.0 мянган төгрөгийн, нийт **9,868.8** мянган төгрөгийн нийтийн тээврийн унааны зардлын нөхөх төлбөр олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, жилийн эцэст төсвийн хэмнэлтийг татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн болно.

Хариулт: 2022 оны санхүүгийн аудитын тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид илэрсэн алдаа, зөрчлийг дахин гаргахгүй байх талаар анхаарч ажиллах болно.

Сонсох ажиллагааг 14.57 цагт дуусгав.

Сонсох ажиллагаанд оролцсон:

Захиргааны төлөөлөл:

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын

Аудитор: _____ / Т.Одсүрэн/

Оролцогч:

Дарга

Нягтлан бодогч



/Ч.Алтантуяа /

/Ц.Цэцэгмаа/

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар
Тайлант хугацаа: 2022.01.01-2022.12.31

Эрсдэлтэй АГАДҮТ-н түвшинд хэрэгжүүлэх түүврийн сорилын үр дүнг үнэлж шийдвэрлэх

№	Нөлөөлж буй АГАДҮТАГАДҮТ-н дэд анги	Товч утга	Мөнгөн дүн	Материаллаг эсэх	Үр өгөөжөөр тооцох эсэх	Шалгуур		Алдаа, зөрчлийн ангилал	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн хариу	Гаргасан шийдэл
						Стандартын заалт	Хууль тогтоомжийн заалт					
1	Мөнгөн хөрөнгө	Мөнгөн урамшуулал давхардуулан олгосон	1,350.00	Материаллаг	тийм	УСНББОУС-1	Төсвийн тухай хуулийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбооой	Төлбөрийн акт тогтоох	Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Төлбөрийн акт тогтоох	Төлбөрийн акт тогтоох
2	Мөнгөн хөрөнгө	Батлагдсан төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан	16,339.80	Материаллаг	үгүй	УСНББОУС-1	Төсвийн тухай хуулийн 6.4.1, ЗГ ын 2019 оны 6 дугаар тогтоолын 8.2, 8.4	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбооой	Албан шаардлага хүргүүлэх	Аудитаар илэрсэн зөрчлийг хүлээн зөвшөөрсөн	Албан шаардлага хүргүүлэх	Албан шаардлага хүргүүлэх
Дүн			17,689.80									

Бэлтгэсэн: Аудитор

Т.Одсүрэн

Огноо: 2023.02.16

Хянасан: Аудитын менежер

Б.Батманх

Огноо: 2023.02.16

Баталсан: Дарга, Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Огноо: 2023.02.16

Танилцаж хүлээн зөвшөөрсөн:

Сэлэнгэ аймгийн БШУТ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Алтантуяа

Нягтлан бодогч:

Ц.Цэцэгмаа





**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗАР**

Цагаан эрэг, 2 дугаар баг,
Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг 213200
Утас, факс: (976)-7036-2165, 7036-2196
Цахим шуудан: selenge@mecs.gov.mn
Цахим хуудас: selenge@mecss.gov.mn

2023.02.14 № 59

танай _____-ны № _____-т

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 1350,0 мянган төгрөгийн төлбөрийн актын үр өгөөжийг хүлээн зөвшөөрч байна.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.АЛТАНТУЯА

D:Бичиг хэрэг/Alban bichig/Явуулсан бичиг 2023/A5

083185

АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	1.2 Аудитын код	СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ
-----------------	---	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ 02/A1870391	1.6 Огноо	2023.02.16	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,350.00
--	-------------------------------------	-----------	------------	----------------------------	----------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	Нягтлан бодогч Ц.Цэцэгмаа, төсвийн мэргэжилтэн П.Золжаргал нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны А/57 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилт			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.4: "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ...", 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн..."			
		Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.4.1		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төрийн хэмнэлтийн тухай хууль		
		Заалт	15.1.3		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль		
		Заалт	21.1		
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал		
	Заалт	4.2.3.3			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1,350.0	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
				2023.06.01

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	БШУГ-ын даргын тушаалаар урамшуулал олгох тухай	2022.12.07 А/57	2022	Байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хууль, журам, стандартын дагуу бэлтгэж тайлагнаж аудитаас "Зөрчилгүй" дүгнэлт авсан үндэслэлээр улирлын мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон байна.

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Т.Одсүрэн	Аудитор	Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар	Дарга	Ч.Алтантуяа	99080401
				Нягтлан бодогч	Ц.Цэцэгмаа	99168568

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
---	-----------------	-------	---------------------------------------	------------

1	Аудитын менежер	11/16	Номингоо Ганзориг Бүтээгч	
2	Тэргүүлэх аудитор	11/16	Зөвлөмж - 11 Зөвшөөрөх Дондоо	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Өгнөө	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа		

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо			
		Дугаар			
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо			
		Дугаар			
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо			
		Ажилтны	Овог нэр		Т.Одсүрэн
			Албан тушаал		Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр		Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар	
		Ажилтны	Овог нэр		Ч.Алтантуяа
			Албан тушаал		Дарга
5	Албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	
		Ажилтны	Овог нэр		Т.Одсүрэн
			Албан тушаал		Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	1	
			Дүн	1350	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 02/А1870391
СЭА 2023/226-ХА-СТР-ДУЗ

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч Ц.Цэцэгмаа, төсвийн мэргэжилтэн П.Золжаргал нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40.0 хувиар тооцож олгосон боловч аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны А/57 дугаар тушаалаар салбарын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,350.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуудан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 : "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3: "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан олгосон 1,350.0 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.

018050005

2. Төлбөрийн актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяа, нягтлан бодогч Ц.Цэцэгмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

АУДИТОР Т.ОДСҮРЭН



АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС

А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх аудит	1.2 Аудитын код	СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ 04/А1870391	1.6 Огноо	2023.02.16	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	16,339.80

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	1. Жилийн эцэс буюу тайлант оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа, хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 4.5 мянган төгрөг байсан / 2022 оны 4 дүгээр сард шинэчлэн тогтоосон / хоолны хөнгөлөлтийг аймгийн БШУГ-ын даргыг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяагийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалаар 13.5 мянган төгрөг болгон 3.0 дахин нэмэгдүүлж, нийт 6,471.0 мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан. 2. Аймгийн төв болох Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээгүй байхад газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалаар хүн тус бүрт өдөрт 2.5-3.0 мянган төгрөгийн, нийт 9,868.8 мянган төгрөгийн нийтийн тээврийн унааны зардлын нөхөх төлбөр олгосон байна.			
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль тогтоомжийн хэрэгжилт			
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)	4.2.1.4: "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ...", 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн..."			
		Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	7.7		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол		
		Заалт	1.1		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль		
		Заалт	21.1		
		Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал		
	Заалт	4.2.1			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд		
	Тухайн байгууллагын дансанд		

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	БШУГ-ын даргын тушаал	А/56	2022.11.21	Батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 4.5 мянган төгрөг байсан хоолны хөнгөлөлтийг а 13.5 мянган төгрөг болгон 3.0 дахин нэмэгдүүлж, нийт 6,471.0 мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан.
2	БШУГ-ын даргын тушаал	А/27	2022.04.22	2. Аймгийн төв болох Сүхбаатар суманд нийтийн тээврийн үйлчилгээгүй байхад хүн тус бүрт өдөрт 2.5-3.0 мянган төгрөгийн, нийт 9,868.8 мянган төгрөгийн нийтийн тээврийн унааны зардлын нөхөх төлбөр олгосон байна.

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Т.Одсүрэн	Аудитор	Сэлэнгэ аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар	Дарга	Ч.Алтантуяа	99080401
				Нягтлан бодогч	Ц.Цэцэгмаа	99168568

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	2/16	Нормын бүрэлдэхүүн бүрдүүлж	
2	Тэргүүлэх аудитор	11/16	Боловсрол - ч хатуу зөвлөмж	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа		

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг		Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо			
		Дугаар			
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо			
		Дугаар			
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо			
		Ажилтны	Овог нэр		Т.Одсүрэн
			Албан тушаал		Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр			
		Ажилтны	Овог нэр		Ч.Алтантуяа
			Албан тушаал		Дарга
5	Албан шаардлага, төлбөрийн актыг хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр		Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар	
		Ажилтны	Овог нэр		Т.Одсүрэн
			Албан тушаал		Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо		
			Дүн		
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 04/АБТ0391

Сүхбаатар

УИА 2023/226-НА-ЕТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах зарчмыг алдагдуулж төрийн албан хаагчдад дараах нөхөх төлбөрийг олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

1. Жилийн эцэс буюу тайлант оны 11 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр унаа, хоолны хөнгөлөлтийн батлагдсан төсөв хэмнэгдэхээр байтал хэмнэлтийг татан төвлөрүүлэхээс зайлсхийж, өдрийн 4.5 мянган төгрөг байсан / 2022 оны 4 дүгээр сард шинэчлэн тогтоосон / хоолны хөнгөлөлтийг аймгийн БШУГ-ын даргыг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяагийн 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/56 дугаар тушаалаар 13.5 мянган төгрөг болгон 3.0 дахин нэмэгдүүлж, нийт **6,471.0 мянган** төгрөгийн нэмэлт зардал гаргасан,
2. Аймгийн төв болох Сүхбаатар суманд нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ байхгүй байхад газрын даргыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/27 дугаар тушаалаар хүн тус бүрт өдөрт 2.5-3.0 мянган төгрөгийн, нийт **9,868.8** мянган төгрөгийн нийтийн тээврийн унааны зардлын нөхөх төлбөр олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2 дахь "Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээтэй хот суурин газарт ажиллаж байгаа энэ журмын 8.1-д зааснаас бусад төрийн албан хаагч нь ажилдаа ирэх, буцахад нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зайлшгүй шаардлагатай бол нийтийн тээврийн унааны зардлын 50 хувийг байгууллагаас нь нөхөн олгоно", 8.4 дэх "Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

018040007

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.4: “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, ...”, 4.2.1.8 “...холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлүүдийг арилган, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Сэлэнгэ аймгийн БШУГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяа, нягтлан бодогч Ц.Цэцэгмаа нарт даалгав.


АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Т.ОДСҮРЭН

The image shows a red rectangular official stamp. Inside the stamp, there is a circular emblem in the center. To the right of the emblem, there is a vertical line of text in Mongolian script. Overlaid on the stamp are two handwritten signatures in black ink. One signature is at the top right, and another is on the left side. The names 'Ч.ЭНХТУЯА' and 'Т.ОДСҮРЭН' are printed in black text to the right of the stamp. The words 'ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР' and 'АУДИТОР' are printed in black text to the left of the stamp. Above the stamp, the text 'АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:' is printed in black.

Тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн ангилал, тэргээлд хамаарах албан тушаалтны ажлын байрны нөхцөл

№/л	Шалгагдагч байгууллагын нэр	Байгууллагын регистр	Төсөв захиралчийн ангилал	Овог тэр	Албан тушаалтны нэр	Хамарах удирдах албан тушаалын ангилал		Удирдах албан тушаалтны ажлын байрны талбайн хэмжээ /м кв/					Ийнхүү талбайн хэмжээ /м кв/	Аудитын илрүүлэлт			Тайлбар
						Удирдах албан тушаалтны нэр	албан тушаалын ангилал /тэргүүн эрхэлсэн түшмэл тэй/	Ажлын өрөө /м кв/	Амралтын өрөө /м кв/	Тусдаа өргөн тосгойн өрөө /м кв/	Уулзалтын өрөө /м кв/	Бусад өрөө /м кв/		Шалгуур үзүүлэлт /хуугийн заалт	Зөрчлийн агуулга	Зөрчлийн шийдэл	
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17
1	Сэтгэвч БНУУГ	9055169	ТЭЗ		Газрын дарга	Тэргүүн түшмэл	36 м кв	0	0	0	0			ЗГ-ын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга хэрэгслийн нийтлэг жишиг"			Газрын дарга томилгодоогүй
2			ТТЗ		Холтөнийн дарга												
3			ТШЗ														
4																	
5																	
6																	
					Дүн												

Гарал, баталгаажуулах өгсөн

Сэтгэвч газрын дарга, баян аажуусан:

Нэгтгэн өгсөн

Газрын даргын үүргийг гүйцэтгэх зүйлс



Хянаж хүтээн илч, баталгаажуулав:

Хариуцаан аудитор, шинжлэгч

Аудитын менежер

2022 А/89

Овог тэр, гарын үсэг

Овог тэр, гарын үсэг

АУДИТЫН АЖЛЫН ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ЭРГЭЦИЙН ХУУДАС

1. Ерөнхий мэдээлэл

Аудитын код	СЭА-2023/226-НА-СТА-ТШЗ		
Баримт бичгийн төрөл	Аудитын тайлагнах үе шатны ажлыг хянах		
Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудит		
Хугацаа заасан эсэх	Тийм		Өгөх ёстой огноо
	Үгүй		
Аудит гүйцэтгэсэн	Аудитор	Т.Одсүрэн	

2. Гүйцэтгэсэн ажлын чанарын хяналтын эргэцийн хуудас

Огноо		Чанарын хяналт хийсэн хүний шийдвэр, үнэлгээ			Чанарын хяналт хийсэн хүний санал, зөвлөмжийн товч утга	Гарын үсэг	Санал, зөвлөмжийн хэрэгжилтэд хийсэн хяналт	Тайлбар
Хүлээн авсан	Буцааж өгсөн	Хангалттай	Засвар, зөвлөмжийг оруулж дараагийн шатанд шилжүүлэх	Засвар хийгээд дахин хянуулах				
14/06	14/06	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Санхүүгийн байдалын тайлангийн үзүүлэлтийг тайлбарлах	Т.Одсүрэн	Замнасан	
14/06	14/06	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Тусламж үзүүлэлтийг анхны бичлэгээр бичих	Т.Одсүрэн	-	
14/06	14/06	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Албан шаардлагаар хяналтын байдал	Т.Одсүрэн	-	
14/06	14/06	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Бүтээлийн хяналтыг илэрхийлэх	Т.Одсүрэн	-	
11/07		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Тусламж үзүүлэлтийг тайлбарлах	Т.Одсүрэн	-	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Албан шаардлагаар хяналтын байдал	Т.Одсүрэн	-	
14/08	11/07	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	Хяналтын байдал	Т.Одсүрэн	-	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
Хуудсыг хянаж хаасан:		Дарга, тэргүүлэх аудитор			Т.Одсүрэн		/Ч.Энхтуяа/	

2022 оны 02 сарын 08 -ны өдөр